

Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

# ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Улаанбаатар хот  
2016 он



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 онд Хан-Уул дүүргийн 59 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын 352 их эмч нар иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж ажиллажээ.

Хүснэгт 1. Дүүргийн эрүүл мэндийн салбарын үзүүлэлт, 2006-2015 он

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Эрүүл мэндийн байгууллага	4	4	4	4	7	7	7	7	7	5
Эрүүл мэндийн нэгдэл	1	1	1	1	1	1	1	1	1	1
Өрхийн эмнэлэг	12	12	12	13	13	13	14	14	14	15
Эмнэлэгийн орны тоо	318	318	318	224	846	846	846	856	968	968
Их эмчийн тоо	128	144	137	127	211	211	186	192	344	352
Хувийн эмнэлэг	14	14	14	14	29	29	25	27	33	39
Эмийн сан	34	46	46	44	39	39	39	39	58	61

2015 оны байдлаар эмнэлэгт үзүүлж үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 789734 болж, өмнөх оноос үзлэгийн тоо 10310 буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

он	Эмнэлэгийн үзлэгийн тоо	Төрөлт	Төрөхийн улмаас эндсэн эх	Амьд төрсөн нярай	Нас баралт	Үүнээс: 0-1 нас
2006	531075	1721	4	1729	539	29
2007	575256	1861	3	1875	588	27
2008	610506	2318	2	2346	601	41
2009	591809	2515	2	2533	538	29
2010	647013	2617	3	2631	608	33
2011	693969	2991	4	2995	642	22
2012	731511	3377	3	3407	649	37
2013	779552	3712	5	3737	602	48
2014	779424	4044	3	4091	704	45
2015	789734	4487	1	4510	610	41

Зураг 1. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд



Дүүргийн хэмжээнд нэг хүртэл насны хүүхдийн эндэгдэл 2015 онд 41, эхийн эндэгдэл 1 гарчээ. Төрөлт 2015 оны байдлаар 4487 болж, өмнөх оноос 10.9 хувиар буюу 443 төрөлтөөр нэмэгдсэн байна. Амьд төрсөн нярайн тоо 2015 оны байдлаар 4510 байгаа нь өмнөх оноос 10.2 хувиар буюу 419 хүүхдээр илүү байна.

2015 онд халдварт өвчнөөр өвчилсөн 3123 тохиолдол бүртгэгдсэн нь 2014 оноос 1.6 дахин буюу 1923 тохиолдлоор, 2013 оноос 1.4 дахин буюу 1858 тохиолдлоор тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн халдварт өвчний гаралт

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Халдварт өвчин	1036	1438	1330	1024	985	1467	2155	1265	1200	3123
Үүнээс:										
Вируст хепатит	195	362	302	190	138	515	289	93	64	35
Улаан бурхан	-	-	-	-	-	-	-	-	-	1643
Гахайн хавдар	209	23	39	92	13	70	715	142	19	17
Меннингит	1	22	4	2	-	1	-	1	2	-
Сүрьеэ	193	216	223	226	246	200	202	216	231	267
Заг хүйтэн	105	172	97	60	41	67	37	33	21	50
Цусан суулга	92	147	165	216	218	143	177	149	172	208
Тэмбүү	73	132	140	79	91	170	136	136	219	196
Бусад	168	364	356	159	238	301	599	491	472	707

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн өсөлтөд улаан бурхан өвчнөөр өвчлөгчдийн тоо 1643 тохиолдол буюу нийт халдварт өвчнөөр өвчлөгчдийн 52.6 хувийг эзэлж байгаа нь голлон нөлөөлжээ. Харин 2015 онд вируст гепатит өвчнөөр өвчилсэн тохиолдлын тоо 35 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 29-ээр буюу 45.3 хувиар, 2013 онтой харьцуулахад 58 тохиолдлоор буюу 62.4 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Зураг 2. Халдварт өвчин, вируст гепатит, 2006-2015 он



Танилцуулга бичсэн:

СХ-ийн мэргэжилтэн Э.Батзаяа